



## НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ - ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛТОТ ЖИЛ-2022

### НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

#### Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар:

-Аймгийн хэмжээнд 2022 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд нийт 320 мянган ширхэг мод, бут тарьж нийт тарьсан модны 36 мянган ширхэгийг айл өрх, 70-аад мянга ширхэгийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, 140 мянган ширхэгийг төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид, 74 мянган ширхэгийг ойжуулалт, хамгаалалтын ойн зурваст тарьж мод бут тарих ажилд нийт 492 аж ахуйн нэгж, байгууллага, 16428 иргэн оролцож, тарьсан модны амьдралтын хувь дундажаар 80 хувьтай ургаж байна.





*Хүрээлэн буй орчинтой зөв зохистой харьцах мэдлэг, зөв дадал хэвшүүлэх зорилгоор Хархорин сумын сургуулийн өмнөх боловсролын 5 байгууллагын 600 гаруй хүүхдүүд өөрийн цэцэрлэгийн орчимд болон Диваажингийн цэцэрлэгт хүрээлэнд 500 гаруй ширхэг мод бут тарьж, ургуулсан байна.*



*Хархорин сумын ШШГХэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги Орхон голын эрэгт болон өөрийн эзэмшлийн талбайд 2470 ширхэг бургас, улиас тарьж, амьдралт 95 хувьтай байна. Ирэх жилүүдэд 100,000 мод тарихаар үрсэлгээг хийсэн байна.*

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн хүрээнд мод тарих, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд аймаг, орон нутгийн төсвөөс 1,552 сая, улсын төсвөөс 90 сая, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлээс 748 сая нийт 2,3 тэрбум төгрөг зарцуулж, аймгийн хэмжээгээр төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оны суурь түвшингээс 31 га талбайгаар нэмэгдсэнээр 176 га боллоо.

### **2.1.1.Ойжуулалт, хамгаалалтын ойн зурвас байгуулах чиглэлээр:**

2022 онд Бат-Өлзий сумын ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлүүд өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх 10 га талбайд ойжуулалтын гүйцэтгэж, сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайд 9000 ширхэг модыг тарьсан.



Улсын төсвөөр гүйцэтгэх газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан суманд хамгаалалтын ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчээр “Их сумт хайрхан” ХХКомпани шалгарч уг ажлыг гүйцэтгэлээ. Нийт 8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж 3500 ширхэг мод бут тарьсан байна.

Арвайхээр, Хужирт, Хархорин, Бүрд сумдад улсын чанартай авто зам дагуу мод тарих ажлыг эхлүүлж, Арвайхээр суманд А301 авто замын дагуу Хурд колонк, Зэвсэгт хүчний 0256 дугаар ангийн орчим 2.5 км урт, 15 метр өргөнтэй хамгаалалтын хашаа барьж 3400 ширхэг мод, Хужирт сумын Рашаан сувилалын орчим “Жем-Хужирт” ХХК, Хужирт рашаан сувилал ХХК 800 метр ойн зурвас, “ӨВ-А33А” ТӨХКомпани нь Бүрд сумын Шарлинд “Алтан шар зам” хөшөөний дэргэд цэцэрлэгт хүрээлэн байгуулж 1000 ширхэг мод тарьж усалгаанд зориулж сумаас 10,0 сая төгрөгөөр худаг гаргуулсан байна.



*Хужирт сумын Рашаан сувилалын орчим “Жем-Хужирт” ХХК, Хужирт рашаан сувилал ХХК 800 метр ойн зурвас, байгуулсан байдал*

Хархорин суманд газар тариалан эрхэлдэг 16 аж ахуйн нэгж 10 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 16 мянган ширхэг мод, Төгрөг сумын Мазарт 6 га талбайг хашиж агро ойжуулалт хийх зорилгоор 1200 ширхэг мод тарьжээ.



*Хархорин суманд газар тариалан эрхэлдэг 16 аж ахуйн нэгж 10 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 16 мянган ширхэг мод, тарьсан байдал*



*“ӨВ-АЗЗА” ТӨХКомпаний нийгмийн хариуцлагын хүрээнд “Алтан шар зам” хөшөөний дэргэд цэцэрлэгт хүрээлэнг Бүрд сумын Шарлингийн орчим байгуулж, 1000 ш улиас мод тарьжээ.*

Улсын төсвөөр гүйцэтгэх газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан суманд хамгаалалтын ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчээр “Их сумт хайрхан” ХХКомпани шалгарч 8 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 3500 ширхэг мод бут тарьсан байна.



Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил



**2.1.2. Ногоон байгууламжийн хашаа хайс, усалгаа арчилгааны чиглэлээр:**

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн талбай, Цэргийн анги, УБ-Арвайхээрийн авто замын дагуу мод тарих 4 хэсэг талбайд 6300 уртааш метр хамгаалалтын хашаа барьж, уг ажилд 75.6 сая төгрөгийн санхүүжилт олголоо.



Хурд колонк 2237,2 метр газар



Өлзийт овоо 554,6 метр газар



Дэлгэрэх 404,2 метр газар



Цэргийн анги 3104 метр газар

Хашааны шонг “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазрын хаягдал хуванцараар хийсэн шонгоор хийсэн бол 12 га талбай бүхий Их монгол цэцэрлэгт хүрээлэнд ус хэмнэх дуслын усалгааны систем авч ашиглахаар боллоо.



*Хужирт сум ногоон байгууламжаа хашаажуулсан байдал:*



*Уянга сумын “Өгөөмөр өргөө” ХХК, “Баярсгоулд” ХХК-иуд нийгмийн хариуцлагын хүрээнд сумын ногоон байгууламжийн хашаа хийсэн байдал*

Аймгийн хэмжээнд мод тарьсан газрын усалгаанд зориулж 16 гүн өрмийн худаг, 3 гар худаг гаргаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авахад нийт 514.1 сая төгрөгийг төр, хувийн хэвшлээс зарцуулсан байна. ХХААХҮЯамны хөдөө аж ахуйг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлээр усалгааны тоног төхөөрөмж нийлүүлэх мэдээллийг сумдад хүргүүлж ажилласнаар 2 аж ахуйн нэгж дэмжлэг авч хямд өртөгтэй дуслын болон намираа усалгааны систем, тоног төхөөрөмж авсан байна.



Аймгийн хэмжээнд “Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд нийт 500 иргэнийг түр ажлын байраар хангаж, сумын ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, модны нүх ухах ажилд 10 хоногийн хугацаатай ажиллуулж 200,0 сая төгрөгийн урамшуулал олгосноос гадна сумдын ЗДТГазрууд бүтэц орон тоондоо багтаан гэрээгээр болон ажил үүрэгт өөрчлөлт оруулах, хавсран гүйцэтгэх байдлаар шийдвэрлэж 24 хүнийг ажиллуулж, Арвайхээр, Хархорин сумдууд ногоон байгууламж, тохижилт үйлчилгээ хариуцсан орон тооны ажилтан ажиллуулсан байна.


### **2.3. Мод үржүүлжгийн газруудыг дэмжих, тарьц суулгацны нөөц бүрдүүлэх**

Аймгийн хэмжээнд тарьц суулгацны нөөц бүрдүүлэх зорилгоор шинээр мод үржүүлгийн газар байгуулах, чадавхижуулах асуудлыг аймгийн зүгээс тодорхой бодлогоор

дэмжин ажиллаж байна. 2022 онд аймгийн нутаг дэвсгэрт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор хангай, тал хээр, говиор бүсчлэн “Арвайхээр-Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ, “Бат-цэрлэгжилт” ХХК, “Сум дундын Ойн анги”, “Өгөөмөр шунхлай” ХХК, “Өв-эхлэл өнгө” ХХК, “Их говийн төгөл” зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 216,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Энэ онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, иргэдийн тоо 11-ээр нэмэгдэж, 2021 онд тус аймгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 10 мод үржүүлгийн газарт 15 нэр төрлийн нийт 327.9 мянган тарьц суулгац ургуулж байсан бол 2022 онд 21 мод үржүүлгийн газарт 18 нэр төрлийн 2,0 сая орчим тарьц суулгац ургуулж байна. Үүнээс 2 настайгаас дээш буюу 2023 онд ойжуулалт цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх тарьц суулгац 340.0 мянга орчим байгаа бол 2024 оноос эхлэн жил тутам 1200.0 мянгаас дээш тооны тарьц суулгацыг нийлүүлэх боломжтой болж байна.



“Арвайхээр-Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ газрын мод үржүүлгийн талбай



*Арвайхээр сумын орон нутгийн хөгжлийн сангаас “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ газарт хайс хашлага барихад 50,0 сая төгрөг, өвлийн хүлэмжний дэмжлэг 90,0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлэсэн бөгөөд мод үржүүлгийн газарт үрээр болон нэг настай тарьцаар хайлаас, улиас, шар хуайс, гүйлс, голтбор, агч, зэрэг нэр төрлийн модыг үржүүлж ирэх онд стандартад нийцсэн 80-140 мянган ширхэг, тарьц суулгацыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад нийлүүлэх боломжтой болсон байна.*


**Бат-Өлзий суман дахь сум дундын ангийн Мод үржүүлгийн газар**





*Мод үржүүлгийн газрын өргөтгөл*





*Бат-Өлзий суман дахь Сум дундын Ойн анги 3 га мод үржүүлгийн газрыг шинээр байгууллаа.*

2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 13 суманд 458,7 га газрыг мод тарих, ногоон байгууламж байгуулах, мод үржүүлгийн газар байгуулах иргэн аж ахуйн нэгжид олгохоор тусгаж 2022 онд 100 орчим га талбайг мод үржүүлэг, ногоон байгууламж байгуулах зориулалтаар олгосон байна.

**Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төсөл Арвайхээр хотод хэрэгжиж эхэллээ.**



Цөлжилтийг бууруулах, шар шороон шуурга, элсний нүүдлээс байгаль орчныг хамгаалах зорилгоор 2007 оноос хойш Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төсөл тус аймгийн Арвайхээр хотод 15 га талбайд мод үржүүлгийн газар байгуулахаар үйл ажиллагаагаа эхлүүлэн нээлтийн арга хэмжээг 2022 оны 10 сарын 06-ны өдөр зохион байгуулж, БНСУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Ли Ё Хун, Нээлтэнд БНСУ-с Монгол улсад суугаа бүрэн эрхэт элчин сайд Ли Ё Хун, БОАЖЯ-ны дэд сайд

Г.Түвдэндорж, Өвөрхангай аймгийн засаг дарга А.Ишдорж болон бусад 70 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо. Төслийн хүрээнд тал хээрийн бүс нутгийг модны үр, тарьц суулгацаар хангах хүчин чадал сайтай мод үржүүлгийн газрыг байгуулахаас гадна иргэд, байгууллагыг арга зүйгээр хангах, экологийн боловсрол олгох, чадавхижуулахад чиглэсэн Мэдээлэл, сурталчилгаа, сургалтын төв байгуулна.



*Тарьц суулгацны үзэсгэлэн худалдаа:*



Бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 2022 онд тарьц суулгац нийлүүлэх ажлыг гүйцэтгэсэн 6 аж ахуйн нэгжээс 26 мянган ширхэг, зорилтот жилийн үйл ажиллагааны зардал, байгууллага аж ахуйн нэгжийн хандив тусламжаар 50 гаруй мянган ширхэг модны суулгац, мод тарих өдрүүдийн хүрээнд зохион байгуулсан тарьц, суулгац борлуулах үзэсгэлэн худалдаагаар мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүд 180 мянга орчим, өөр аймаг, хотоос оролцсон аж ахуйн нэгжүүд 40 орчим мянган тарьц суулгац борлуулсан байна.



### **2.1.3. Бүх сумдад соёл амралтын болон цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг зохион байгуулах талаар:**

Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд 12 га талбай бүхий “Их Монгол” цэцэрлэгт хүрээлэн, Дэлгэрэх гол дагуу “Залуус”, “Моби гарден” зэрэг бичил цэцэрлэгт хүрээлэнгүүд, Хархорин, Хужирт, Баянгол, Сант, Өлзийт сумдууд бичил цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулж бусад сумдууд хуучин цэцэрлэгт хүрээлэндээ мод бут тарих, тохижуулах ажлууд хийгдсэн байна.



**Дэлгэрэх гол төслийн сүүлийн үе шат “Залуус” цэцэрлэгт хүрээлэн**



*Мобиком корпорациас Арвайхээр хотын төв талбайд “Моби гарден” цэцэрлэгт хүрээлэнг нээлээ. 2023 м2 талбайг 40 гаруй сая төгрөгийн санхүүжилтээр тохижуулж, иргэдийг ая тухтай ногоон орчинд амарч зугаалах боломжийг бүрдүүлээд байна.*



*Хархорин сум орон нутгийн төсвийн 88,7 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн паркийн зориулалттай 2.3 га газрыг хашаажууллаа.*

*Бүрд сум хуучин байгуулсан 2 цэцэрлэгт хүрээлэнгээ өөрсдийн хүчээр шинэчлэн засварлаж, мод бут тарих ажлыг зохион байгуулсан байна.*



**2.1.5. Нийгмийн хариуцлагын хүрээнд мод бут тарих чиглэлээр гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн хэрэгжүүлсэн ажлын талаар:**

Зорилтот жилийн хүрээнд аймгийн хэмжээнд 474 аж ахуйн нэгж, байгууллагатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, шинээр байгуулагдсан 31 га талбай бүхий ногоон байгууламжид 70 орчим мянган ширхэг мод тарьсан. Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашаа барих, өөрсдийн зардлаар мод тарих, тарьц суулгац нийлүүлэх, тарьсан модыг усалж арчлах, усалгааны эх үүсвэр гүний худаг гаргах, бичил цэцэрлэг, авто зам дагуу ойн зурвас байгуулснаас гадна иргэд ах дүү, төрөл садан, сургууль төгсөгчид, нутгийн зөвлөлөөрөө нийлж орон нутагтаа олон бүтээлч ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажилласан байгууллага, аж ахуйн нэгжүүдээс Арвайхээр сумын “Ноос ирээдүй” ХХК, Мобиком корпораци, Уянга сумын “Аум-алт” ХХК, Бат-Өлзий сумын “Их сумт хайрхан” ХХК, Хужирт сумын “Жем-хужирт” ХХК, Хайрхандулаан сумын иргэн Б.Отгоннасан, Хайрхандулаан сумын бичил уурхайчид зэрэг олон аж ахуйн нэгж, байгууллага, иргэд зорилтот жилийн ажилд идэвх санаачлагатай оролцлоо.

## 2.1.6. Мод бут тарих чиглэлээр сургалт сурталчилгаа, зохион байгуулж, зөвлөмж, гарын авлага бэлтгэж иргэдэд суталчлах чиглэлээр:

"Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жил"-ийн хүрээнд иргэдэд мод бут тарих, чиглэлээр 11 удаагийн сургалт, 2 уулзалт, 1 зөвлөгөөн зохион байгуулж, 5 төрлийн ном, гарын авлага, зөвлөмж гаргаж иргэд олон нийтэд хүргэсэн. Зорилтот жил болон Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, мэдээ мэдээллийг олон нийтэд цаг алдалгүй хүргэх зорилгоор Орон нутгийн "Соёмбо", "Хас" болон МҮОНР телевиз, ӨВ live.mn сайт, эх бэлтгэлийн "Оюунана брэнд" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж,



мод бут тарих чиглэлээр 20 эх бэлтгэл, сурталчилгааны постер, 32 удаагийн мэдээ, 6 сэдвийн сурвалжлага, 10 шторк, хийлгэн, улиас, хайлаас, жимсний мод тарих арга, аргачлалын талаар нэвтрүүлэг бэлтгэж аймгийн томоохон вэйб сайт болон байгууллагын пэйж хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчилж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд шилдэг тохижилт, ногоон байгууламжтай сум, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, сургууль, цэцэрлэг шалгаруулах болзолт уралдаан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Супер анги" шалгаруулах

уралдааныг тус тус зохион байгууллаа.

Зорилтот жилийн нээлт, зөвлөгөөнд оролцогчдод зориулж мод тарих болон хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр дараах сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгууллаа.

"Тэрбум мод" тарих стратеги төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам (БОАЖЯамны Ойн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Р.Ганбат)

- Монгол-Солонгосын "Ногоон хэрэм" төслийн танилцуулга (Төслийн менежер Ч.Одсүрэн)
- Мод тарьж ургуулах шинжлэх ухааны үндэслэл Ш.Шинэбаяр (ХААИС-ийн багш, судлаач докторант)
- Агро-ойн аж ахуйг хөгжүүлэх боломж, арга зам А.Буянбаатар (ХААИС-ийн захирал доктор Ph.D)



- Жимс жимсгэний салбарын тулгамдсан асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, жимсний мод тариалах арга технологи Монголын жимс, жимсгэний үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн У.Насанжаргал
- Өвөрхангай аймагт 20,0 сая мод тарьж, ургуулах төлөвлөлтийн талаар (видео танилцуулга)
- Ногоон ажлын байр хөтөлбөрийн танилцуулга ХХҮГазрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга С.Даваасүрэн

- Хог хаягдлын салбарын өнөөгийн нөхцөл байдал, хог хаягдлыг дахин боловсруулах салбарын зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ (Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны ТУЗ-ийн дарга “Хэв хашмал” ХХК-ны захирал Э.Хүдэрбаатар)



- Аюултай хог хаягдлын судалгаа авч хэрэгжүүлэх арга хэмжээ (ХХЭБҮХ-ны тэргүүн доктор Ph,D Г.Чинзориг)
- Хатуу хог хаягдлын менежмент /Арвайхээр хотын жишээн дээр/ (Аймгийн төвийн Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн олон нийтийн оролцоо хариуцсан зөвлөх Ж.Амарсайхан)
- Ногоон зээлийн бүтээгдэхүүн, танилцуулга (Хаан

банкны зээлийн багц хариуцсан мэргэжилтэн Б.Буянтогтох)

- Хуванцар савыг орлох ган сав үйлдвэрлэлийн Чиглэл компаний танилцуулга (Чиглэл компаний захирал Ц.Бумцэнд)

Арвайхээр сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчдад зориулсан мод бут тарих арга аргачлалын талаарх сургалтыг 2022 оны 3 сарын 15-ны өдөр зохион байгуулж 80 гаруй албан хаагч оролцлоо.



*Өсвөр үеийн хүүхэд багачуудад экологийн боловсрол олгох чиглэлээр ЕБС-ын Эко клубын хүүхдүүдтэй хамтран төрөл бүрийн нөлөөллийн ажлууд зохион байгуулж ажиллалаа.*





*Хархорин сумын ЕБС-ийн Эко клубийн гишүүн сурагчид мод, цэцэг тарих, хаягдал зай цуглуулах, хог хаягдлаа ангилан ялгах талаар зарим албан байгууллага, аж ахуйн нэгжид мэдээлэл өгч, ногоон байгууламжаа нэмэгдүүлэхийг уриаллаа.*

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

-oOo-